

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын бүтцийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

2024.07.10

Албан тушаалын тодорхойлолтыг

баталсан огноо:

Байгууллагын нэр:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 380 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./

Албан тушаалын нэр:

Гэр булийн хөгжил, хамгааллын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Гэр булийн бодлогын газрын Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтэс

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 380 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, Т3-7

Ажлын байрны албан ёсны байршил:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-5, Улаанбаатар-15160

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Гэр булийн хөгжил, хамгааллын асуудлаар урт, дунд, богино хугацааны бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг газар, хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар урт, дунд, богино хугацааны бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 2.Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар дүн шинжилгээ хийж, холбогдох бодлогын баримт бичгийн тесэл боловсруулах, төлөвлөлтийн тухай, Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцын болон Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргах;
- 3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих асуудлаар хууль тогтоомжийг боловсруулах, боловсронгуй болгох;	Боловсруулсан төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан, бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдсан байна.	Г
	2.Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар хууль тогтоомжид заасан дагалдах дүрэм, журам, стандарт, хөтөлбөр, гарын авлага боловсруулах;	Хуулийг дагалдах дүрэм, журмын төсөл боловсруулсан байна.	Г
	3.Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаарх хууль тогтоомжид үр нөлөөллийн үнэлгээ хийх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, өөрчлөлт оруулах талаар төсөл боловсруулах;	Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан байна.	Г
	4.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, холбогдох дүрэм, журмыг боловсруулах, боловсронгуй болгох;	Хуулийг дагалдах дүрэм, журмын төсөл боловсруулсан байна.	Г
	5.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, холбогдох дүрэм журмыг боловсруулах;	Хуулийг дагалдах дүрэм, журмын төсөл боловсруулсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох бодлогын төсөл боловсруулах;	Боловсруулсан төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагыг	МОНГОЛ УЛС ЗОВШЮОРОГ ТӨРИЙН АЛБАНЫ ДОВЛЭЛ 2


		хангасан, бусад хууль ТОГТООМЖ, бодлогын баримт бичигтэй уялдсан байна.	
	2. Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар стратеги, урт, дунд, богино хугацааны бодлогын төслийг боловсруулах, төлөвлөх;	Боловсруулсан төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан, бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдсан байна.	Г
	3. Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах төсөл боловсруулах;	Боловсруулсан төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан, бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдсан байна.	Г
	4. Гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөлт, тооцоо хийх;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шаардлагыг хангасан, бусад бодлогын баримт бичигтэй уялдсан төлөвлөлт, тооцоолол хийсэн байна.	Г
	5. Гэр бүлийн хөгжил, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, хохирогчид хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах төлөвлөгөөг боловсруулах;	Төлөвлөгөөг хүний нөөцийн хэрэгцээ шаардлагын дагуу боловсруулсан байна.	Г
	6. Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцын болон хэрэгжилтийн тайланг гаргах;	Тайлан мэдээлэл нь хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой байна.	Г
	7. Монгол Улсын хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг гаргах;	Тайлан мэдээлэл нь хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой байна.	Г
	8. Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргах;	Тайлан мэдээлэл нь хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой байна.	Г



		байна.	
З дугаар зорилтын хүрээнд	1.Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хагас, бутэн жилээр тайлагнах;	Албан тушаалын тодорхойлолт болон нэгжийн төлөвлөгөөтэй уялдсан байна.	Г
	2.Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах;	Тайланг тогтоосон хугацаанд бүрэн, оновчтой тайлагнасан байна.	Г
	3.Хариуцсан асуудлын чиглэлээр хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтооолын төсөлд санал өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, мэргэжил арга зүйгээр хангах;	Бодлогын үндэслэлтэй санал өгсөн байна.	Г
	4.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх, хариу хүргүүлэх;	Өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг шуурхай шийдвэрлэсэн байна.	Г
	5.Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зохион бүрдүүлж буй баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах;	Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан хөтөлж, архивд хүлээлгэн өгсөн байна.	Г
	6.Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зерчлээс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.	Албан тушаалын чиг үүргээ хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн хамгаалалт /092/; - Нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /031/; - Эрх зүй /0421/; - Боловсрол /011/; - Менежмент ба удирдахуй /041301, 041303, 041306, 041307/; - Үйлдвэрлэл, боловсруулалт /072/. 		
Мэргэшил			
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээллийг шинжилж, шийдвэр гаргах, үр дагаврыг үнэлэх; - мэдээлэлд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах; - эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч 	



		<ul style="list-style-type: none"> - хэрэгжүүлэх; - шийдвэрийн үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнд шинжилгээ хийх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх гарц, арга замыг тодорхойлох; - хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, хариу өгөх; - хуульд тогтоомжид нийцсэн санал, зөвлөмж боловсруулах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг өөрөө хариуцах; - удирдлагыг шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн туршлага, үр чадвар, мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, хамтран ажиллах; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг сонсож, санал санаачилгыг дэмждэг байх; - асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа маргаан бүхий асуудлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэй технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах; - бусад.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хүүхэд, гэр бүлийн хэлтсийн дарга



Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга

/Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 380 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Нийт:

Бусад харилцах субъект:

1. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, албан хаагчид;
2. Харьяа агентлаг, байгууллагын холбогдох албан тушаалтан;
3. Төрийн бусад байгууллага, холбогдох албан тушаалтан;
4. Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт
боловсруулсан:

Албан тушаал:

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГА *B. Aley* Б. АЛИМАА

(Гарын үсэг)(Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)
2024 оны 09 дүгээр сарын 08 -ны өдөр

ATA12944 9132155 9024070592

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 24.09.2024

Дугаар: 082

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2024.09.28

Дугаар: А/70

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Л. Мөнхзүл* Л. МӨНХЗҮЛ

(Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 09 дүгээр сарын 08 -ны өдөр